

БАТЛАВ:

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Л.МӨНХЗУЛ

Улаанбаатар хот

2025 оны 10 сарын 28-ний өдөр

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЗОРИУЛЖ ТОХИРУУЛГА, ТОХИЖИЛТ
ХИЙСЭН АЖЛЫН БАЙР, АЖИЛ ОЛГОГЧИЙН САЙН ТУРШЛАГЫГ ОЛОН НИЙТЭД
СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

АЖЛЫН ЗОРИЛГО: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх, бие даан идэвхтэй амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж буй байгууллага, аж ахуй нэгж, иргэнд зориулсан тэдэнтэй харилцах, үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлэх, нийгэмд эерэг хандлага, мэдээллийг түгээхэд оршино.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

Эхлэх хугацаа: 2025 оны 11 дугаар сарын 05-ны өдөр

Дуусах хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

НЭГ.ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсад 2024 оны байдлаар нийт 107.9 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэнээс 87.3 мянга нь хөдөлмөрийн насны хүн байна. Эдгээр хүмүүсийн 15 хувь буюу 16.2 мянган хүн хөдөлмөр эрхэлж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Иймд хөгжлийн бэрхшээлийн талаарх ажил олгогчдын ойлголт хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тохируулга, тохижилт хийсэн ажлын байр, ажил олгогчийн сайн туршлагыг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг хийж, эерэг ойлголт хандлагыг түгээх улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх, байнгын ажлын байраар хангагдах шаардлага байна.

ХОЁР. АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тохируулга, тохижилт хийсэн ажлын байр, ажил олгогчийн сайн туршлагыг олон нийтэд сурталчлан таниулах мэдээллийг боловсруулах, түгээх ажлыг гүйцэтгэнэ.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Багцад тусгагдсан ажлын тоо, төсөл, арга хэмжээ бүрээр дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

№	Гүйцэтгэх ажил	Агуулга	Тоо ширхэг	Шаардлага	Төсөв мян төг)	Хугацаа
1	Телевизийн мэдээний агуулга бэлтгэх	- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрийн талаарх хууль эрх зүй - Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулж буй ажил олгогчийн сайн туршлага - Хөгжлийн бэрхшээлтэй хүн ур чадварыг харуулсан	5	- Контент, сурвалжилга нь олон нийтэд ойлгомжтой, хүний эрхэд суурилсан байх - Хөгжлийн бэрхшээлтэй хүний нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэсэн үг хэллэг, дүрслэлийг ашигласан байх; - Уламжлалт болон сошиал медиа сувгуудын онцлогт тохируулан мессэжний хэлбэр, агуулгыг боловсруулсан байх; - Үр дүн нь бодитоор олон нийтэд хүрсэн, хэмжиж болохуйц үзүүлэлттэй байх; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ойлгомжтой, дохионы хэлний орчуулгатай байх.	3,000	XI/10-XI/15
2	Нэвтрүүлгийн агуулга бэлтгэх	Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулж буй ажил олгогчийн сайн туршлага, хөдөлмөрлөх эрхийн талаар	2		1,200	XI/16-XI/18
3	Контентын загвар бэлтгэх		3		600	XI/20-XI/30
5	Постер	Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулж буй ажил олгогчийн сайн туршлага, хөдөлмөрлөх эрхийн талаар тоон мэдээллийг багцалсан зурагтай	5		500	XII/10 -XII/20
7	Мэдээ, нэвтрүүлгийн эх бэлтгэл	Бэлтгэсэн агуулгын хүрээнд бэлтгэх	7	- хүний эрхийн мэдрэмжтэй, ялгаатай хэрэгцээг хүндэтгэх; - нийтийн эрх ашгийг хүндэтгэж, тэгш шударга байх; - хууль дээдэлж, зохиогчийн	5,700	XII/1

				эрхийг зөрчихгүй байх; • хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл, оролцоонд тулгуурлах; • мэдээлэл нь хөгжлийн бэрхшээлийн тохируулгатай байх; • мэдээлэл нь үнэн, бодитой, нотолгоонд тулгуурласан байх; • Захиалагч өөрийн болон бусад мэдээллийн хэрэгслээр түгээж болох		
8	Мэдээ, нэвтрүүлэг бэлтгэх цацах, түгээх	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын өдөр болон түүнээс хойш хугацаанд	7	мэдээ радиогийн 1 сувгаар	3,000	XII/3-XII/20
			8	контент, постер 1 сайтаар	1,000	
9	Эцсийн тайлан ирүүлэх	Бэлтгэсэн мэдээллийн файлаар хавсаргах	1	Тайлан 15 ширхэг бүтээгдэхүүн		XII/20

ДӨРӨВ.ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Гүйцэтгэгч нь баг, хуулийн этгээд байж болно.

Туршлага:

- Хөгжлийн бэрхшээл, түүний төрөл хэлбэр, онцлогийн талаар ойлголттой, тус салбарт ажиллаж байсан туршлагатай гишүүнтэй байх;
- Хууль, эрх зүй, хүний эрхэд суурилсан мэдээлэл боловсруулах чадвартай байх;
- Орчин үеийн мэдээллийн технологид суурилсан, боловсруулалт хийх ур чадвартай байх;
- Олон нийтэд мэдээлэл хүргэх сувагтай байх;
- Ижил төрийн ажил гүйцэтгэсэн туршлагатай байх.

ТАВ.ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ

Тус яамны Гэр бүлийн бодлогын газар, хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтэн үйл ажиллагаанд хяналт тавина.

ЗУРГАА.САНХҮҮЖИЛТ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил хамгааллын чиглэлээр туссан хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээ зардлаас санхүүжүүлнэ. Арга хэмжээний төлбөр нь 15,000,000 /арван таван сая/ төгрөг байна.

Явцын тайлан ирүүлэхэд төлбөрийн 50 хувийг, эцсийн тайланг хүлээлгэн өгөхөд, хянаж үлдэгдэл төлбөрийг төлнө.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд төлбөрт бүх зардал, татвар, хураамж багтсан болно.

ДОЛОО.БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- Байгууллагын гэрчилгээний хуулбар
- Сонгон шалгаруулалтад оролцох албан хүсэлт
- Байгууллагын танилцуулга, мэдээлэл
- Байгууллагын өмнө нь ижил төстэй ажил хийж байсан танилцуулга
- Тоног төхөөрөмжийн жагсаалт, үнийн саналын мэдээлэл

---oOo---